

**БЭЭЖИН БАРЫН ГЭСЭР БА ЛУН-ФУ-СЫ-ГИЙН ГЭСЭРИЙН
АВИАНЗҮЙН ОНЦЛОГ**

С.Батхишиг¹

Бээжин барын Гэсэр² болоод барын Гэсэрийн агуулгын хувьд үргэлжлэл гэж хэлж болох Лун-Фу-Сы(*Lóng fú sī*, 6 бүлэг)-гийн Гэсэрийн тууж нь бусад монгол бичгийн Гэсэрийн туужуудаас ярианы хэлний махбодыг илүү тусгаснаараа онцлог бөгөөд зөвхөн хооронд нь харьцуулахад л тухайн үеийн хэлний онцлогийг тодруулахуйц баримт цөөнгүй олдono³. Зохиогч энэ өгүүлэлдээ Бээжин барын Гэсэр болоод Лун-Фу-Сы(*хойшид Лун Гэсэр гэв*)-гийн Гэсэрийн авианзүйн онцлогийг хооронд нь харьцуулж адил ба ялгаатай талыг тодруулсан юм. Ер нь Бээжин барын Гэсэр нь ярианы хэлний онцлогийг илүү тусгасан бол Лун Гэсэр нь Бээжин барын Гэсэртэй харьцуулбал бараг бичгийн хэлний маягтай боловч бичгийн хэлтэй харьцуулахад, ярианы хэлний жишээ ихтэй байна.

1. Бичлэгийн онцлог

Барын эх нь үсгийн махбод тод ялгагдахаар бол Лун Гэсэрийн эх нь зарим үсгийн махбод андуурагдахаар бичигджээ. Тухайлбал, Лун Гэсэрийн эхэд хамаатуулахын -ni(ᠨᠢ) нөхцөлийг бичихдээ олон газар n(ᠨ)-ийн цэгийг тавилгүй бичиж, n(ᠨ)-ийн шүдийг шилбэ мэт уртавтар татсаны улмаас эгшгээр төгссөн үгэнд дагуулдаг заахын тийн ялгалын -yi(ᠶᠢ)-тэй адил болжээ. Мөн Лун Гэсэрийн эхэд үгийн дунд орсон -r(ᠷ), -y(ᠶ) хоёрыг төдий л ялгамжгүй бичсэн, зарим газар үгийн дунд орсон -j(ᠵ)-г үгийн эхний -j(ᠵ)-гээр тэмдэглэсэн, үгийн эхний j(ᠵ), y(ᠶ)-г ялгалгүй (ᠷ)-гээр бичсэн зэрэг ялгаа буй.

Ер нь, Лун Гэсэрийн эх нь сонгодог монгол бичгийн дүрмээс гажуудуулалгүй бичихийг зорьсон, илүү эртний хэв маягийг хадгалсан эх болох нь харагддаг. Мөн монгол бичгийн хэлний эрт үеийн онцлог бичлэг болох *toyus* (1203a03) < mb. *toyus* > kh. *toᠶs*; *nisuysan*⁴ (1208a10) < mb. *nisūgsen* > kh. *nissēn* мэт үг нь тухайн үеийн монгол түүхэн сурвалжуудад ч төдий л тохиолддоггүй.

¹ Доктор. МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

² *Arban jūg-ūn ejen Geser qaᠷin-u tuᠷji orosiba*, 1716, 7 бүлэг.

³ Бээжин барын Гэсэрийн туужийн хэлний онцлогийн талаар Н.Поппе `Монгол Гэсэрийн хэлний онцлогт холбогдох судалгаа` (1926), И Сөн Гюү `Бээжин барын Гэсэрийн хэлний судалгаа` (2008) зэрэг өгүүлэл гарснаас гадна И Ги Мүнь `Мон-о нуголдэ-гийн судалгаа` (1964)-ндаа Гэсэрийн туужийн нэлээд жишээг дурдсан байна.

⁴ *niskū* ~ *nisqu* гэсэн энэ хоёр үг нь угтаа гарал нэг, чанга, хөндий эгшгээр сэлгэсэн нэг үгийн хоёр хувилбар байснаа хожим утга нь салж эм эгшигт үг нь *нисэх*, эр эгшигт үг нь зөвхөн хүүр чандар ясыг шатааж сүнсийг нь дэгдээх гэсэн утгатай болон хэвшсэн байна.

2. Авианы хувьсал – Эгшиг

Урт эгшгийн хөгжил. Урт эгшгийг Гэсэрт нэгдүгээрт, монгол бичгийн дүрмийн дагуу тэмдэглэсэн, хоёрдугаарт, VCV-ийн байран дахь гийгүүлэгч (*Intervocalic consonant*) сугарч хоёр талын эгшиг бүрэн ижилсэн орчин цагийн монгол хэлний урт эгшиг үүссэн байдлаар, гуравдугаарт, орчин цагийн монгол хэлний VCV-ийн байран дахь гийгүүлэгч сугарч хоёр талын эгшиг ижилсэж амжаагүй байсан байдал гэсэн 3 янзын хэлбэрээр тэмдэглэсэн байна.

а. Урт эгшиг үүссэн жишээ

VCV бүтцийн хоёр эгшгийн дундах гийгүүлэгч сугарч хоёр талын эгшиг нь бүрэн ижилссэн жишээ Бээжин барын Гэсэрт системтэйгээр маш олон тохиолдох бол Лун Гэсэрт дараах жишээнд авсан цөөн хэдэн үгээс өөрөөр бараг тохиолдохгүй.

- Mo. -aγa- > kh. -aa- Барын эх: *qāba* (0424b19) < mb. *qaγaba* > kh. *xāv*
Лун Гэсэр: *alād* (1106b10) < mb. *alayaḍ* > kh. *alād*
- Mo. -aγu- > kh. -aa- Барын эх: -
Лун Гэсэр: *asāqu* (1235a04) < mb. *asaγuqu* > kh. *asūx*
- Mo. -aγi- > kh. -aa- Барын эх: *siyāji* (0547b11) < mb. *šayaγiju* > kh. *shagāidž*
Лун Гэсэр: -
- Mo. -uγ(~b)a- > kh. -aa- Барын эх: *sonusāsai* (0420b17) < mb. *sonusuyaṣai* > kh. *sonsōsōi*
Лун Гэсэр: *alaqār* (1133b10) < mb. *alagu-bar* > kh. *alāxār*
- Mo. -ege- > kh. -ee- Барын эх: *teretē* (0419b16) < mb. *teretege* > kh. *teritē*
Лун Гэсэр: *degē* (1126b22) < mb. *degege* > kh. *degē*
- Mo. -ūge- > kh. -ee- Барын эх: *ūjelē* (0111b20) < mb. *ūjelūge* > kh. *ūzlē*
Лун Гэсэр: -
- Mo. -aγu- > kh. -uu- Барын эх: *qaruul* (0509a16) < mb. *qaraγul* > kh. *xarūl*
Лун Гэсэр: -
- Mo. -uγu- > kh. -uu- Барын эх: *urūl* (0132a16) < mb. *uruγul* > kh. *urūl*
Лун Гэсэр: *čulbūraban* (1128a24) < mb. *čulbuγur-īyan*
- Mo. -iγu- > kh. -uu- Барын эх: *šuurγan* (0127a21) < mb. *siγurγan* < kh. *shūrgā*
Лун Гэсэр: -
- Mo. -egū- > kh. -ūū- Барын эх: *kečūū* (0407a01) < mb. *kečegūū* > kh. *xetsū*
Лун Гэсэр: *tūkei* (1143b14) < mb. *tegūkei* > kh. *tūxī*
- Mo. -ūgū- > kh. -ūū- Барын эх: *tūrūūlen* (0511b11) < mb. *tūrūgūlūn* > kh. *tūrūlēn*
Лун Гэсэр: *tūrū* (1124b22) < mb. *tūrūgūū* > kh. *tūrū*
- Mo. -eyi- > kh. -ii- Барын эх: *čūimi* (0111b21) < mb. *teyimū* > kh. *tīm*
Лун Гэсэр: *kičēgči* (1219b05) < mb. *kičiyegči* > kh. *xichēgch*
- Mo. -igi- > kh. -ii- Барын эх: *siire* (0543b07) < mb. *sigir-e* > kh. *shūr*
Лун Гэсэр: *kīri* (1025a19) < mb. *kigiri*

Монгол бичгийн хэлний зүйн зөв бичих дүрмээр хоёр гэдэс (ᠮ {oo, uu, öö, üü}) давхарлан бичих ёс (ᠮool; qoor-a; küü) буй боловч сонгодог монгол бичгийн хэлэнд шүд, шилбэ (ᠮ {a,e}, ᠮ {i}) давхарлан бичиж урт эгшиг тэмдэглэх ёс байхгүй билээ. Гэвч Гэсэрийн туужид шүд, шилбэ (ᠮ {a,e}, ᠮ {i}) давхарлан бичиж урт эгшиг тэмдэглэсэн жишээ цөөнгүй тохиолдоно.

Барын эх: *čüimi* (0127a22, 0112a03) < mb. *teyimā* > kh. *ūm*

Лун Гэсэр: *amarīi* (1363b14) < mb. *amaray-a* > kh. *amrāy* > Col. *amrī*⁵

Лун Гэсэр: *baay-a-dur* (1372a03) < mb. *bayatur*

Лун Гэсэр: *yaabu*⁶ (0905a10) < mb. *Yabu*

в. Хоёр эгшгийн дундах гийгүүлэгч сугарч хоёр талын эгшиг ижилсэж амжаагүй хос эгшгийн байдалтай жишээнүүд барын Гэсэрт маш олон тохиолдох бол Лун Гэсэрт маш цөөн, 3-4-өөс илүү тохиолдохгүй бөгөөд монгол бичгийн CVC хэлбэрээр бичсэн.

Барын эх: *qaurayad* (0517a20) < mb. *qayuruyad* > kh. *xūrād*

bileüdebe (0425b17) < mb. *bilegüdebe* > kh. *bilüdeḅ*

Лун Гэсэр: *lausa-iyān* (1024b08) < mb. *layusa-ban* > kh. *lūsā*

kečēü (1273b13) < mb. *kečegüü* > kh. *xetsü*

с. Дээрх хоёр зүйлийн ярианы хэлбэрийг тэмдэглэснээс гадна Гэсэрийн туужид тухайн үеийн монгол бичгийн дурсгалууд болоод хэлзүйн толь бичгүүдэд тэмдэглээгүй хэлбэрүүд буюу эртний монгол хэлний урт эгшгийг тэмдэглэсэн жишээнүүд олонтоо тохиолдоно. Тухайлбал, толь бичгүүдэд *samsa*, *jüger*, *öčüken* гэж бичихээр дүрэмжсэн үгүүдийн эртний хэлбэр буюу *samsayan* (0132a07), *jügeger* (0138b07), *öčügüken* (0514a14) зэрэг бичлэг тохиолдохоос гадна *egüü-ber* < mb. *egüber* (0605b26), *qooruja* < mb. *qoruja* (0566b21), *qurim-uud* < mb. *qurim-ud* (0148a02) зэрэг бичгийн хэлний дүрмээс гажиж урт эгшгийг тэмдэглэсэн жишээ ч олон буй⁷. Ер монгол бичгийн хэлний

⁵ Одоогийн өвөрлөгч, халхын аман ярианд -я, -е, -ё зэрэг үйл үгийн биеэр төгсгөх нөхцөлийг урт -ī-гээр хэлэх нь түгээмэл. Энэ авианзүйн хувьсал 17-18-р зууны үеэс эхэлсэн байжээ.

⁶ Монгол бичгийн хэлэнд а, е буюу шүд (ᠮ) давхарлан урт эгшгийг тэмдэглэх оролдлого байсан гарч байсан гэж зарим эрдэмтэд үзсэн байна. Учир нь санскрит хэлнээс монгол хэлэнд орсон *mahā rāja*-г монгол бичгийн хэлээр ~~ᠮᠠᠬᠠᠷᠠᠵᠠ~~ (*mahā rāja*) гэж тэмдэглэсэн байдаг байна (О.Сүхбаатар, *Харь үгийн толь*)

⁷ Гэсэрийн туужид урт эгшгийн хувьслын өөр нэг хэлбэр Geser.I. *boroyan* (0404a01) < mb. *boroyan* > kh. *borō*; Geser.II. *uyur* (1365a21) < mb. *ayur* > kh. *ūr* зэрэг үгс олон тохиолдох ба хэвтээ дөрвөлжин бичгийн дурсгалд мөн *bargon* (4a.1) < mb. *barayun* > kh. *barün* гэж тохиолдоно. Эдгээр жишээнүүдээс одоогийн халх аялгуунд үлдсэн *эгэм* гэдэг шиг тухайн үед хоёр эгшгийн дундах гийгүүлэгч сугаралгүй хэлэгдэж зарим нутгийн аялгуунд үлдсэний жишээ юм. Одоогийн халх аялгууны *эгэм* гэх үгийг зарим нутгийн аялгуунд, тухайлбал ойрд аялгуунд *ээм* гэдэг. Үүнтэй адил хоёр эгшгийн дундах гийгүүлэгч сугараагүй олон жишээ үлдсэн олон жишээ бүхий аялгуу бол буриад аялгуу юм. Жишээ нь, bur. *tagaalal* < mb. *taᠵaal* > kh. *iäläl*; bur. *elgeebe* < mb. *ilegebe* > kh. *ilēv, ilgēv*; bur. *qurgan* < mb. *quruᠵu* > kh. *qurū*; bur. *nurgan* < mb. *niruᠵuᠨ* > kh. *nurū*. Мөн сартуул аман аялгуунд *долоон* гэхийг *долоогон* гэдэг байна.

дүрмийн олон толь бичгүүд 17-18-р зууны үед зохиогдсон бөгөөд сонгодог монгол бичгийн хэлний дүрмийн дагуу боловсруулсан боловч нэгэнтээ урт эгшигтэй болсон зарим үгийг эртний дуудлагаар нь бус тухайн үеийн хэлний дуудлагаар толь бичигт оруулан хэвшүүлсэн байна.

*Хос эгшиг*⁸

Гэсэрийн туужид орчин цагийн монгол хэлний хос эгшгийн байранд тохиолдох *Vy* үеийг бичгийн хэлний зарчмаар тэмдэглэсэн. N.Porpe *Гэсэрийн туужийн хэлний судалгаа*-ндаа хос эгшгийг нэгэн бүлэг болгон, монгол бичгийн хэлний *-eyi*-гийн байранд *-ii-* хос эгшиг тохиолдож байна гээд *kiliigsen < keleyigsen*⁹; *jigijū < jigeyijū* зэрэг жишээ тааралдаж буйг дурдсан байна (N.Porpe, 1998 (*солонгос орчуулга*); 242-р тал). Гэвч эдгээр үгийн хоёр эгшгийн дундах гийгүүлэгч сугараад гийгүүлэгчийн дараах өргөлтөт *ī*-д гийгүүлэгчийн өмнө байсан *-e-* татагдаж ижилсэн *-ii-* урт эгшиг үүссэн хэрэг юм. Өөрөөр хэлбэл, *teyimū < tīm*; *eyimū < īm* зэрэг орчин цагийн монгол хэлний *-ий*-гийн *урт эгшигийг* үүсгэсэн байна. Хэрвээ *-eyi*-гээс хос эгшиг үүсэх бол *-ei-* хос үүсэх ёстой.

Эгшгийн ижилсэл (assimilation)

Монгол хэлний түүхэн хөгжлийн дундад үеийн монгол хэлний үеэс нэг үгийн доторх эгшиг авиа нь аль хүчтэй эгшигтээ татагдах байдлаараа ижилсэн хувьсч байсан нь монгол хэлний дундад үеийн дурсгалуудад тэмдэглэгдсэн байдаг. Ихэнхдээ монгол хэлэнд уруулын эгшиг нь тэргүүн болон тэргүүн бус үеийнхээ авиаг өөртөө татан ижилсүүлэх болжээ. Гэсэрийн хэлэнд уруулын эгшгийн нөлөөгөөр дэвшин ижилссэн ба ухран ижилссэн жишээ цөөнгүй байх ба дундад монгол хэл болон орчин цагийн халх аялгуунаас ялгаатайгаар уруулын эгшиг уруулын бус эгшигтээ ижилссэн жишээ их тааралдана.

Уруулын эгшгийн дэвшин ижилссэн нь (progressive assimilation)

Барын эх: *boroyon* (0404a01) < mb. *boroyan* > kh. *borō*

moro (0138a22) < mb. *mori*

Лун Гэсэр: *uyur* (1365a21) < mb. *ayur* > kh. *ūr*

*ūtūr*¹⁰ (1006a20) < mb. *ūdter* > kh. *Ūtēr*

⁸ Монгол хэлний хос эгшгийн үүслийг томьёолбол, РМ. **V+g/γ+ī* > АМ. **V+y+ī* > ММ. *Vī* > МоМ. *Vī*.

⁹ Энэхүү *kiliigsen < kileyigsen* хэмээх үгийн авианы сэлгэцээр үүссэн эр үг *kilaviγsan* нь орчин цагийн халх аялгуунд *xilāīsān* болсон.

¹⁰ Гэсэрийн туужид уруулын эгшгийн нөлөөгөөр ижилссэн зарим жишээ нь одоогийн халх аялгууны эгшгийн ижилшлээс ялгаатай байна. Жишээ нь, *moro* (0138a22) (Мо. *mori* ~ kh. *mori*); *ōrlōnōi* (0557b01) (Мо. *ōrlūgen-ū* ~ kh. *ōglōōnī*); *ōkūi-būn* (0604b03) (Мо. *ōkūi-ben* ~ kh. *ōkūigēn*). Энэ нь одоогийн *буриад*, *дагуур* зэрэг аялгууны уруулын эгшгийн ижилслийн жишээ юм.

Ухран ижилсэл (*regressive assimilation*)

Барын эх: *ümkübe* (0412b10) < mb. *emkübe* > kh. *ümхэв*
ǫrgǫji (0558a22) < mb. *ergǫjǫ* > kh. *ǫrgǫdž*

Уруулын бус эгшигийн ижилссэн нь

Барын эх: *tabdayar* (0569b10) < mb. *tabuduyar* > kh. *tavdugār*
kegeji (0145a19) < mb. *kógegejǫ* > kh. *xóǫdž*
kebegün (0127a17) < mb. *kóbegün* > kh. *xóvgün*

Лун Гэсэр: *čider* (1017b15) < mb. *čidūr* > kh. *chǫdǫr*

Эдгээр уруулын эгшиг нь уруулын бус эгшигтээ татагдан ижилссэн жишээд нь халх аялгуунд бараг бүгд уруулаар ижилссэн. Харин *i*-гийн хугарлын нөлөөгөөр эгшиг ижилссэн олон жишээний нэг орчин цагийн монгол хэлний үгийн эхний *ǫ* эгшиг ухран ижилсэж *e* болсон ба тэдгээр жишээний зарим нь төв халх аялгуунд ч эгшиг сэлгэн хэрэглэгдсээр байгаа билээ.

Барын эх: *gebsibe* (0403b08) < mb. *gǫbsibe* > kh. *gevshiw* ~ *gǫvshǫw*

Эгшигийн нэмэгдэл

Орчин цагийн монгол хэлний буриад аялгуунд монгол хэлний хоёрдугаар үеийн эгшгүүд харьцангуй тогтвортой тод хэлэгдсээр буй. Харин халх аялгуунд тэргүүн бус үеийн эгшиг балархайшиж нэгдүгээр үеийн өргөлтөт эгшгээс арай балархай дуудагдах болсон. Ойрад зэрэг зарим аялгуунд бүүр балархайшиж харин монгол бичгийн хэлний урт эгшиг нь богиноор дуудагдах болсон байна. 17-18-р зууны монгол хэлний толь бичгүүдэд балархайшсан эгшиг бүхий үгсийг дүрэмжүүлэн тэмдэглэсэн нь орчин цагийн монгол хэлэнд уламжилсан. Гэтэл тэдгээр эгшиг балархайшсан үгсийг Гэсэрийн сурвалжид эгшигтэйгээр тэмдэглэсэн байна.

a. mb. *egúsker* > Geser. *egúseger* (0425a08)

b. mb. *bǫgtūr* > Geser. *bǫgútūr* (0132b16)

c. mb. *činday-a* > Geser. *činaday-a* (0406a01)

d. mb. *qanba* > Geser. *qanaba* (0544b18)

Тухайн үеийн толь бичгүүдэд ч ярианы хэлний онцлогоор буюу эгшиг балархайшсан хэлбэрээр дүрэмжсэн дээрх үгс нь яагаад эгшигтэйгээр тэмдэглэгдсэн бэ. Орчин цагийн монгол хэлэнд ч дээрх үгсийн балархай эгшиг хэлэгдэж буй. Өөрөөр хэлбэл, бичигт тэмдэглэхдээ эгшиггүй тэмдэглээд хэлэхдээ балархай эгшигтэй хэлж байсан байна.

3. *Авианы хувьсал* - Гийгүүлэгч

(*b* ~ *ʏg* ~ *y*) гийгүүлэгчийн сугарал, сулрал

Монгол бичгийн хэлний хоёр эгшгийн дундах (-b- ~ -γ/-g- ~ -y-) гийгүүлэгч (*Intervocalic consonant*) сулран сугарснаар урт эгшиг үүссэн, эсвэл өргөлтөт урт эгшгийн нөлөөгөөр (-b/m- ~ -γ/g- ~ -y-) гийгүүлэгч сулран сугарч гийгүүлэгчийн өмнөх балархай эгшигтэйгээ ижилссэн ба урт эгшгийн үүсэл нь гийгүүлэгчийн сугаралтай огт хамааралгүй гэх саналууд бий. Ямартай ч орчин цагийн монгол хэлний урт эгшгийн байранд VCV гэсэн бүтэц байсан нь тодорхой юм. Энэ хоёр зүйлийн саналын үндэс болсон хоёр эгшгийн хоорондох гийгүүлэгч сугарсан жишээ маш олон тохиолдох бол мөн гийгүүлэгчийн хоёр талын эгшиг ижилссэн ч (-b- ~ -γ/-g- ~ -y-) гийгүүлэгч сугараагүй тэмдэглэгдсэн жишээ ч олон буй. Жишээ нь, *b ~ γ/g ~ y* сугарсан:

Барын эх: *urūl* (0132a16) < mb. *uruyul* > kh. *urūl*

Лун Гэсэр: *nāna* (1338a06) < mb. *naγan-a* > kh. *nānā*

olanar (1291b15) < mb. *olan-iyar* > kh. *olnōr*

b ~ γ/g ~ y сугараагүй:

Барын эх: *boroyon* (0404a01) < mb. *boroyan* > kh. *borō*

Лун Гэсэр: *uyur* (1365a21) < mb. *aγur* > kh. *ūr*

Нэр үгийн нөхцөл дэх хамжих (-b-) сэлгэж -γ/g- болсон ба орчин цагийн монгол хэлэнд хоёр эгшгийн хоорондох -γ/g- сугарч урт эгшиг үүсч 17-18-р зууны монгол хэлэнд хадгалагдсаар байсан ба богино эгшигт үгэнд залгасан нөхцөлийн гийгүүлэгч сугарч орчин цагийн монгол хэлэнд хос эгшиг ба урт эгшигийг заагласан -γ/g- нь хэвээр үлдсэн.

Лун Гэсэр: *yosuyār* (1004a14) < mb. *yosu-bar* > kh. *yosōr*

būgūde-gēr (1014b10) < mb. *būgūde-ber* > kh. *būgdēr*

Барын эх: *aqayiyān* (0121b18) < mb. *aqai-bān* > kh. *axaigān*

ōsiy-e-gēn (0549b15) < mb. *ōsiy-e-bēn* > kh. *ōshōōgōō*

Мөн заахын тийн ялгалын хувьд эгшгээр төгссөн үгэнд залгадаг '-yi' нөхцөлийг -gi-гээр тэмдэглэсэн ба орчин цагийн монгол хэлэнд үгийн эцсийн -i эгшиг балархайшиж -γ/-g үлдсэн.

Лун Гэсэр: *kāigi* (0110a18) < mb. *kāi-yi* > kh. *xūig*

toy-a-gini (0529a22) < mb. *toy-a-yi ni* > kh. *tōg ni*

Барын эх: *senglon-gi* (0541b24) < mb. *senglon-yi* > kh. *Senglong*

-n- гийгүүлэгчийн нэмэгдэл

Лун Гэсэр-ийн туужид тохиолдож буй нэгэн сонирхолтой онцлог бол орчин цагийн монгол хэл болоод монгол бичгийн хэлэнд байхгүй -n- гийгүүлэгчийг тэмдэглэсэн явдал юм. Ихэнхдээ гийгүүлэгчийн өмнө тохиолдоно.

čayansun (1119b24, 1119b25) < mb. *čayasun ~ čayalsun* > kh. *tsās*

monlur (0904a04) < mb. *molur* > kh. *molör*
nikenji (0802a21) < mb. *nekejü* > kh. *nexädž*
olonsugsen (1377a01) < mb. *ölüsügßen* > kh. *ölssön*
tenden-i (1006b11) < mb. *teden-i* > kh. *tednġ*
aduyulanju (1354a11) < mb. *aduyulaju* > kh. *adüldž*

Энэ мэт гийгүүлэгчийн өмнө тохиолдох хамрын гийгүүлэгч өмнөх эгшгээ хамаршуулан сугарах болсон нь дундад монгол хэлний дурсгал “Монголын нууц товчоон”-д тэмдэглэгдсэн нь бий. Жишээ нь, *nuntay* < mb. *nutag* > kh. *nutäg*. Дээрх жишээнүүд нь энэ хувиралтай адил зарчимтай байна. Мөн хамрын гийгүүлэгч хажуугийн -l- -ээр сэлгэж сулран сугарсан жишээ ч монгол хэлний онцлог юм. Жишээ нь, *čayansun* (1119b24) < mb. *čayalsun ~ čayasun* > kh. *tsās*. Солонгос хэлний *nün* хэмээх үгийг монгол хэлний *nidü*-тэй нэг гаралтай гээд эртний хэлбэрийг сэргээвэл **nindün* болох ба Гэсэрийн сурвалжид тохиолдож буй дээрх жишээнүүд нь алтай хэлний баримттай холбогдох эртний монгол хэлний онцлог жишээнүүд байж болох юм.

Бээжин барын эхэд дээрх мэт -л- гийгүүлэгчийн сугаралын жишээ үгийн үндсэнд нэр үгийн нөхцөл залгахад нэг удаа тохиолдох ба мөн гийгүүлэгчийн өмнөх -l-; -r- сугарсан жишээ тохиолдоно.

čimandur (0606a04) < mb. *čim-a-dur* > kh. *chamd*
bilčiraju (0126b24) < mb. *bičaraju* > kh. *biltsarch ~ bicharch*
örmürge (0127a25) < mb. *örmüg* > kh. *örmög*

Мөн Лун Гэсэрт орчин цагийн монгол хэлэнд гийгүүлэгчийн өмнө орсон шүргэх -γ- сугарсан жишээ тааралдана..

čoyčiqu (1203b05) < mb. *sočiqu* > kh. *chochix*
babaqai (1125a24) < mb. *baybaqai* > kh. *baywāxāi*

Гийгүүлэгч давхарлах ёс

-g- гийгүүлэгч давхарласан нь. Энэ гийгүүлэгч нь Бээжин барын Гэсэрт -n-; -ng-; -g-/γ- гийгүүлэгчийн дараа тогтвортой тохиолдох ба Лун Гэсэр болоод Монгол түүхэн сурвалжуудад цөөхөн боловч тохиолдож байна. Жишээ нь:

Барын эх: *čotung-gi-yin* (0142b15) < mb. *čotung-un* > kh. *Tsotongġin*
siruy-gin (0146a14) < mb. *siruy-un* > kh. *shurgġin*

Лун Гэсэр: *čerig-gini* (1376b22) < mb. *čerig-i-ni* > kh. *tsergġni*

-n- гийгүүлэгч давхарласан нь. Мөн дундад үеийн монгол хэлний дурсгалуудад тийн ялгалын нөхцөл залгахад тэмдэглэсэн байдаг -n(n)- гийгүүлэгч давхарлан орсон жишээ Гэсэрийн хоёр эхэд түгээмэл тохиолдоно.

Барын эх: *ebügen-nei* (0113b06) < mb. *ebügen-ü* > kh. *övgönġi*

sayinnar (0115a18) < mb. *sayin-iyar* > kh. *sainār*

qanni (0505a18) < mb. *qan-u* > kh. *xānī*

Лун Гэсэр: *čilayun-ni* (1354a19) < mb. *čilayun-i* > kh. *chulūnīg*

kūmūn-nei (1235b26) < mb. *kūmūn-ū* > kh. *xūnī*

modun-ni (1364a18) < mb. *modun-i* > kh. *modīg*

Гийгүүлэгчийн сэлгэлт ¹¹

Гэсэрийн туужийн хоёр эхэд дараах мэт гийгүүлэгч сэлгэсэн жишээ тааралдана. Монгол хэлний гийгүүлэгч авиа нь авиалагдах байрлалын хувьд ойр авиалбар сэлгэсэн боловч утгын хувьд ямар ч өөрчлөлт үгүй.

† хажуугийн {l} ~ хамрын {n}

*loyta*¹² (1017b04) < mb. *noytu* > kh. *nogt*

† Уруулын хамжих {b} ~ хамрын {m}

qabar (0111a10) < mb. *qamar* > kh. *xamār*

† хамрын {m} ~ {n} ~ {ng}

*minggerbe*¹³ (1247a05; 1272a13) < mb. *nimgerbe* > kh. *nimgērēv*

† хамрын {n} ~ хамжих {γ}

*sununay*¹⁴ (1124b17) < mb. *suynay* < kh. *sūnāg*

sunubar (1133a16) < mb. *suyn-bar* < kh. *sugār*

† хамжин шүргэх {č} ~ шүргэх {s}

čoyčiqu (1203b05) < mb. *sočiqu* > kh. *chochīx*

sigiči (1360b22) < mb. *čigčii* > kh. *chigchī*

† хамжих {k} ~ шүргэх {s}

silayan-a (1126b20) < mb. *kilayan-a* > kh. *x`algānā*

† хамжин шүргэх {č} ~ хамжих {k}

kōm (0103b17) < mb. *čōm*

Гэсэрийн туужийн эдгээр жишээнүүд нь монгол хэлний нийт аялуудад түгээмэл тохиолддог гийгүүлэгчийн сэлгэлтийн жишээ юм. Тухайлбал, монгол хэлний эхэн ба

¹¹ Орчин цагийн монгол хэлний авианзүйн номуудад авианы өөрчлөгдөн хувьсахыг 1. Нөлөөтөн хувьсах (нэг авиа бусад авианы нөлөөгөөр ижилсэх, ондооших, сулрах, сугарах, гээгдэх, нэмэгдэх, тонгорох зэргээр хувьсах); 2. Сэлгэлт (бусад авианы нөлөөллөөс үл хамааран авиалагдах байрлалын хувьд аль ойролцоо авиатай солигдох) гэж хоёр зүйл болгон тодорхойлсон байна.

¹² Орчин цагийн халх. *nogt*, буриад. *nogto*, халимаг. *nokt*, даг. *lonto*; монгол хэлний төв аялгуунаас эрт салсан *dun. loto*, бао. *loxtе*. Үүнтэй адил халх, буриад, халимаг зэрэг аялгуунд п-ээр хэлдэг олон үгийг дагуур, дунсян, баонь аялгуунд л-ээр хэлдэг байна. Жишээ нь, mb. *emūn-e*; kh. *ōmnō*; *bug. ōmnō*, *khal. ōmn*, даг. *emel*, *dun. melie*, бао. *mele*.

¹³ Үгийн эхний *n* нь *m* болсон жишээ дунсян, баонь аялгуунд их тохиолддог байна.

¹⁴ *γ* > *n*; *j* > *n* : Өвөг монгол хэлний онцлог.

дунд орсон хажуугийн *l*, хамрын *n* сэлгэх нь түгээмэл үзэгдэл юм. Жишээ нь, *niux* ~ *liux*; *melxii* ~ *menxii* гэх мэт. Үүнтэй адилаар уруулын гийгүүлэгчид ч орчин цагийн нийт монгол аялгуунд сэлгэдэг нь түгээмэл үзэгдэл. Жишээ нь, *bolxi* ~ *molxi*; *bolor* ~ *molor*. Үгийн дунд орсон хамрын *n* ~ *m* сэлгэдэг олон жишээд ч мөн монгол хэлний нийт аялгуудад үлджээ. *nileen* ~ *mileen*; *ningen* ~ *nimgen*; *undaa* ~ *umdaa* гэх мэт.

Монгол хэлний халхын салбар аман аялгуудад *i* эгшгийн өмнө орсон үгийн эхний *x*- гийгүүлэгч тагнайшиж *sh*- гийгүүлэгчтэй сэлгэх тохиолдол цөөнгүй бөгөөд буриад аялгуунд {*k*} гийгүүлэгчийг {*s*} гийгүүлэгчээр дууддаг болсон байна. Мөн 17-р зууны монгол хэлний дурсгал болох *Qarilcaγan-u bičig*¹⁵-г *ᠴ, s*, *s, ᠴ*, *l, n*, *n, m*, *b, m* зэрэг гийгүүлэгч харилцан сэлгэцэж хэрэглэгдэх үзэгдэл *ᠴačuli, sačuli*, *ᠴikir, sikir*, *mangluγ, mangnuγ* гэх мэт үгэнд илэрдэг нь бидний дээр дурдсан жишээдтэй тохирно.

Сонирхолтой нь *Sečengγuw*-а *mangnuγ* гэх бичлэг бол бичгийн хэлний бичлэг байж, *mangluγ* гэх бичлэг бол ярианы байдлыг тусгасан бичлэг болно гэжээ. Өвөрлөгчдийн аялгуунд *mangluγ* нь ярианы хэлбэр болж хөгжсөн байхад төв халх аялгуунд эсрэгээр *mangnuγ*¹⁶ нь ярианы хэлний хэлбэр болжээ.

Нөхцөл бүтээврийн авианы хувьсал

Нөхцөл бүтээвэр нь үгзүйн асуудал боловч Гэсэрийн туужид үгийн үндэсээс илүүтэйгээр авианзүйн онцлогийг үзүүлж буй хэсэг тул Гэсэрийн туужид тохиолдож буй нөхцөлүүдийг тоймлон үзүүлж тайлбар хийв.

Харьяалахын тийн ялгал

-nai/-nei : Монгол хэлэнд харьяалахын тийн ялгалын *-ai/-ei* хэлбэр байсан бөгөөд *зоогийн* гэхийг *зоогой*, *сангийн* гэхийг *сангай* гэж байсан баримт 20-р зууны эхэн үед хүртэл байжээ. Энэ хэлбэр орчин цагийн буриад аялгуунд илүү идэвхитэй хэрэглэгддэг. Орчин цагийн халх аялгуунд *манай*, *танай* зэрэг төлөөний үгэнд үлдсэн. Үүний монгол бичгийн хэлний *-n*-тэй үгийн дараа тохиолдох *-nai/-nei* хэлбэр Гэсэрийн хоёр хувилбарт хоёуланд нь буй.

Бээжин бар

Лун Гэсэр

aljiγaysan-nai(=m.b. u) (0567a04)

qan-nai(=m.b. u)(1283b12)

ebūgen-nei(=m.b. ū) (0113b06)

kūmūn-nei(=m.b. ū)(1235b26)

-i-yin : Харьяалахын тийн ялгалын бичгийн хэлний бус хувилбар. Тухайн үед хэрэглэгдэхээ больсон **-un/-ūn** нөхцөлийг **-yin** нөхцөлөөр сольж бичихэд гийгүүлэгчид

¹⁵ *Sečengγuw*-а, *Arban doluduγar jaγun-u emūn-e qaγus ūy-e-yin manju mongγol-un qarilcaγan-u bičigūn kelen-ū sudulul* (Докторын зэрэг горилсон бүтээл), ОМYS, 2007, 65-р тал.

¹⁶ *mangnuγ* нь угтаа хятад гаралтай үг (*О.Сүхбаатар, Харь үгийн толь*). Уг хэлбэр нь үгийн дунд *-n*- гийгүүлэгчтэй боловч яриа ба бичигт *manglai* ~ *mangnai* гэдэг үгийн адилтгал (*аналоги*)-аар *mangluγ* гэдэг үг бий болжээ. Мөн *-la*² хэмээх үйлийн үг бүтээх дагавар ихэвчлэн *-ng* төгссөн үгийн дараа *-na*² болдог.

дагадаг ёс¹⁷ ыг бодон -i эгшгийг жийрэглэсэн бололтой.

Бээжин бар	Лун Гэсэр
<i>yool-i-yin</i> (= <i>yool-un</i>) (0109a08)	-
<i>eres-i-yin</i> (= <i>eres-ün</i>) (0131a10)	<i>geser-i-yin</i> (= <i>geser-ün</i>)(1229b20)

-gi-yin : Харьяалахын тийн ялгалын бичгийн хэлний бус хувилбар. Эгшгээр төгссөн үгийн дараа болоод, **-ng-** гийгүүлэгчээр төгссөн үгийн дараа харьяалахын тийн ялгалын **-ийн** нөхцөл залгахад **-г-** жийрэглэдэг тогтвортой шинжтэй болж бичгийн хэлэнд ч ийн тэмдэглэгдэх болжээ.

Бээжин бар	Лун Гэсэр
<i>yow-a-gi-yin</i> (= <i>yow-a-yin</i>) (0503a21)	-
<i>keriy-e-gi-yin</i> (= <i>keriy-e-yin</i>) (0505b03)	<i>degūgi-yin</i> (= <i>degū-yin</i>) (1303a01)

-yi-yin : Харьяалахын тийн ялгалын ярианы хэлний элемент. Гэсэрийн хоёр хувилбарт эм үгэнд тохиолдохгүй.

Бээжин бар	Лун Гэсэр
<i>čotung-yi-yin</i> (= <i>čotung-un</i>) (0562a17)	<i>saba-yi-yin</i> (= <i>saba-yin</i>)(1291a07)

Заахын тийн ялгал

-gi : Заахын тийн ялгалын бичгийн хэлний бус хэлбэр. Ихэвчлэн эгшгээр төгссөн болоод **-n**, **-ng**, **-g**-гээр төгссөн үгэнд залгасан. Мөн биеийн төлөөний зарим үгэнд заахын тийн ялгалын нөхцөлийн хойноос давхар залгасан¹⁸.

Бээжин бар	Лун Гэсэр
<i>ayula-gi(-yi)</i> (0118a23)	<i>olja-gi</i> (= <i>olja-yi</i>) (1202b13)
<i>čotung-gi</i> (= <i>i</i>) (0403b07)	<i>jiryalang-gi</i> (= <i>jiryalang-i</i>) (1319a18)
-	<i>čimayigi</i> (= <i>čimayi</i>) (1305b10)
-	<i>tani-gi</i> (= <i>tan-i</i>) (1320b02)

-i-yi : Заахын тийн ялгалыг давхар нөхцөлөөр гаргасан хэлбэр. Бээжин барын Гэсэрт л тохиолдоно.

<i>qosiyu -čin-i-yi</i> (= <i>qosiyučin-i</i>) (0526b08)
<i>yurban qan-i</i> (= <i>qan-u</i>) <i>sayid-i-yi</i> (= <i>sayid-i</i>) (0561a03)

Гарахын тийн ялгал

-deče/-teče : Гарахын тийн ялгалын дундад эртний монгол хэлний хэлбэр. Гарлын хувьд **-da/-de + -ča/-če = -dača/-deče**; **-a/-e + -ča/-če = -ača/-eče** үүссэн гэж үздэг. Дундад

¹⁷ Монгол бичгийн хэлний *эгшиг жийрэгдэх ёс* нь гийгүүлэгчээр төгссөн үйл үгийн үндсэнд гэдэс(е) буюу -u-; нэр үгийн үндсэнд шүд, шилбэ буюу -a/e-, -i- (· ·) жийрэглдэг зүйл ажиглагддаг. Жишээ нь, *yabuγul + γsan = yabuγuluγsan* (ᠶᠠᠪᠤᠭᠤᠯᠢ ᠶᠤᠰᠠᠨ); *jūil + s = jūilγs* (ᠵᠦᠢᠯᠢ ᠰ).

¹⁸ Монгол хэлэнд тийн ялгалын нөхцөл давхарлан ордоггүй. Түүхэн хэлзүйн үүднээс тийн ялгалын нөхцөл давхарлан орсон тохиолдол байх боловч давхарлан орсон тийн ялгалын хоёр нөхцөлийн эхнийх нь хэлзүйн утга, үүргээ алдсан байна.

монгол хэлний сүүл үе хүртэл идэвхтэй хэрэглэгдэж байсан энэ *-dača/-deče* нөхцөл нь Гэсэрийн хэлэнд зөвхөн хүндэтгэлийн утгатай болсныг хам текстээс мэдэж болно.

Бээжин бар Лун Гэсэр
mgri-teče(=*deče=eče*) (0140a13) *mgri-deče*(=*mgri-eče*) (1001a07)

Үйлдэхийн тийн ялгал

-ar/-er : Үйлдэхийн тийн ялгалын ярианы хэлний хэлбэр.

Бээжин бар Лун Гэсэр
jalgiqar(=*jalgiqu-bar*) (0426a01) *alaqar*(=*alaqu-bar*) (1133b10)
kebtaker(=*kebtəkū-ber*) (0311a21) *semeger*(=*sem-iyer*) (1202b25)

-q-a/qa /-ke : Дундад монгол хэлнээс уламжлалтай бичгийн хэлний нөхцөл. Үйлт нэрийн *-x*-ийн хойноос үйлдэхийн тийн ялгалын нөхцөл залгагдаж хураагджээ.

Бээжин бар Лун Гэсэр
abaq-a(=*abqu-bar*) (0511a05) *ablaq-a*(=*abalaqu-bar*) (1232a22)
neng-jike(=*nengjikū-ber*) (0142b17) *kōkegūlūke*(=*kōkūgūlkū-ber*) (1349a02)

Гэсэрийн хоёр сурвалжид бичгийн хэлний бүх хамаатуулах нөхцөл тааралдахаас гадна тэдгээр нөхцөл тийн ялгалын нөхцөлийн араас орохдоо эгшиг ижилсэх, урт эгшиг үүсэх, гийгүүлэгч сугарах, гийгүүлэгч жийрэглэх гэх мэт олон авианы хувирлыг үзүүлжээ.

-ā : Бичгийн хэлний *-iyan* нөхцөлийн хоёр эгшгийн дундах гийгүүлэгч сугарч гийгүүлэгчийн дараах өргөлтөт *ā* эгшигтээ татагдан ижилсэж орчин цагийн монгол хэлний *-a*⁴ нөхцөлийн хэлбэрт шилжсэн жишээ юм.

čotung-i küliged aduyun-ā(=*aduyun-iyen*) *taɣuji*(=*taɣuju*) (0524b10)
qatun-anu qar-a bay-a(=*bay-iyen*) *urida idegen-i ḡlūsbeū*(=*ḡlūsbe-ūū*) *ged* (1236b15)

-i-iyen (Mo. *-yin-iyen* > kh. *-iinxaa*²) : Монгол бичгийн хэлний *-yin-iyen* давхар нөхцөлийн харьяалахын тийн ялгалыг ярианы хэлний *-i*-гээр тэмдэглэж хамаатуулах нөхцөлийг залгасан байна.

beri-i-iyen(=*beri-yin-iyen*) *aliy-a ayidangyui-yi mini medebeū* (0402b05)
taniyan(=*tan-u-ban*) *emūne*(=*emūn-e*) *oɣuju ūkūy-e geǰū bile* (0905b22)

-i-ken (Mo. *-yin-iyen* > kh. *-iinxee*) : Монгол бичгийн хэлний *-yin-iyen* давхар нөхцөлийн харьяалахын тийн ялгалыг ярианы хэлний *-i*-гээр тэмдэглэж хамаатуулах нөхцөлийн ярианы хэлбэр залгасан байна.

činiken(=*činu-yin-iyen*) *yabudal-iyar kikū buyu* (0514b19)

-dun (Mo. *-du-ban* > kh. *-daan*) : Өгөх оршихын тийн ялгалын нөхцөл *-du* дээр хамаатуулах нөхцөл *-ban* залгахад хоёр эгшгийн дундах *-b-* суларан сугарч гийгүүлэгчийн дараах *-a-* эгшиг уруулын эгшигт татагдан ижилссэн байна.

aqadun (=aq-a-du-ban) ᠔gbe (0141b18)

-tayan-iyān (Mo. *-tayan* > kh. *-tān*)/**-degen-iyen** (Mo. *-degen* > kh. *-dēn*)

Өгөх оршихын тийн ялгал дээр хамаатуулах нөхцөл залгасан нийлмэл бүтэц дээр дахин хамаатуулах нөхцөл залгасан байна.

duyun-tayan-iyān (=aduyun-dayan) taiyam(=taiyan) bolyaju (0541b25)

či minu ečikūi-degen-iyen (=ečikūi-dū-ben) garudi bolju eči (1208b15)

-den (Mo. *-degen* > kh. *-dēn*) : Өгөх оршихын тийн ялгал дээр хамаатуулах нөхцөл залгасан нийлмэл бүтцийн хоёр эгшигийн дундах гийгүүлэгч сугарч урт эгшиг үүссэн ярианы хэлний нөхцөл.

urban ᠔kūi-den(=᠔kūi-dū-ben) jalbariyad (1016b11)

-yiyan (Mo. *-yi-ban* < kh. *-iigaan*) : Заахын тийн ялгалын нөхцөл дээр хамаатуулах нөхцөл залгасан ярианы хэлний хэлбэр.

aqaiyan (=aqai-yi-ban) ūkūgsen ūgei gejū bayitala(=bayital-a) amidura(=amidu-bar-iyān) aladay buyu (0121b18)

-yan/-gen (Mo. *-yi-ban/ben* > kh. *-gaan/-geen*) : Ихэвчлэн урт юм уу хос эгшгээр төгссөн үгэнд залгасан заахын тийн ялгалын ярианы хэлбэр.

degūgen (=degū-ben) čimai(=čimayi) ᠔merem(=᠔mūgerem) (0130b21)

lam-a uum(=um) gekūi-gen (=gekū-yi-ben) martayad (0426b14)

-gi-gen/-yi-yan (Mo. *-yi-ban²* > kh. *-gān⁴*) : Заахын тийн ялгалын *-yi* ба хамаатуулах *-ban* нөхцөлүүдийн гийгүүлэгч суларсан жишээ.

ilayūsan urban ᠔kūi-gen(=᠔kūi-ben) jalbariba (0410a03)

čimayi-yan(=ban) sanaqula(=sanaqul-a) sayuju bayiju (1258a22)

-aran/-eren (Mo. *-iyar-iyān²* > kh. *-aaraa⁴*) : *-iya-* бүтцийн *-y-* гийгүүлэгч сугарч хоёр талын эгшиг ижилсэн урт эгшиг үүссэн ярианы хэлний нийлмэл бүтэц.

jasa šuumar bide *urbayularan*(=urbayula-bar-iyān) (0519b17)

qoyar bolud *sūkeren*(=sūke-ber-iyen) čuru(=čuyuru) čokilayad orum (0424b20)

Товч дүгнэлт

Бээжин барын Гэсэр нь мөн өвөрлөгчдийн аялгууны онцлогийг их тусгасан ба Мун-о Нуголдэ 「蒙語老乞大」¹⁹-тэй бараг ойролцоо аялгуу буюу харчин хорчин сахар ордос аялгууны аль нэгэнд тулгуурласан бололтой.

Лун Гэсэр нь сонгодог монгол бичгийн хэлний дүрэм журмыг илүү барьсан ба Бээжин барын Гэсэрийг бодвол ярианы хэлний онцлогийг бага тусгасан ба монгол хэлнээс эрт салсан *дунсянь*, *баонь* зэрэг аялгууны онцлогийг илүү тусгасан байна.

¹⁹ Мун-о Нуголдэ-гийн авианзүйн онцлогийн талаар С.Батхшиг, “Монгол хэлний гурван ном”-ын авианзүйн онцлог, Acta Mongolica, National University of Mongolia, Vol. 9(320), 2009, 27-38-р талаас үзнэ үү.

SUMMARY

In this article, author compared the colophons of 'Beijing Geser' and 'Longfusi Geser' (Lóng fú sī) and tried to define the phonetic peculiarities of them. 'Beijing Geser' is considered to be written more colloquially while 'Longfusi Geser' was in classical Mongolian. But, to compare other monuments of that period 'Longfusi Geser' has many examples written in oral way.